

**НИЙГМИЙН БОДИТ АМЬДРАЛ  
ДЭЭРХИ АРДЧИЛСАН ҮЙЛ ЯВЦ**

Ч.БААТАР

Санко коллеж

**Түлхүүр үг:** "Адилсалд тулгуурласан" (identitive) буюу тоталитар ардчилал, "өрсөлдөөний" (competetive) буюу олон ургальч ардчилал (polyarchy), ардчиллын даяарчлал, ардчилалд шилжих сонирхол, ардчиллын хөгжлийн түгээмэл үйл явц, ардчиллын бэхжилт.

**Товч агуулга:** Орчин үеийн нийгмийн хөгжлийн үйл явц нь ардчилсан үзэл баримтлалд тулгуурлаж байна. Энэхүү ардчиллын үзэл баримтлал нь нийгмийн бодит амьдрал дээр ямар ойлголтуудаар дамжин биелэлээ олдог тухай өгүүлсэн болно.

Орчин үеийн нийгэм дээрх бодит үйл явцуудыг улс төрийн философийн үүднээс "адилсалд тулгуурласан" (identitive) буюу тоталитар ардчилал болон "өрсөлдөөний" (competetive) буюу олон ургальч ардчилал (polyarchy) гэсэн ойлголтуудаар илэрхийлж болно.

Энэхүү адилсалд тулгуурласан<sup>1</sup> ардчиллын тухай онолыг анхлан нь Францын нэрт философич Ж.Ж. Руссо боловсруулсан гэж үздэг. Түүний үзлээр, нийгмийн хөгжлийн тууштай байдал, ард түмний нэгдмэл хүсэл, сонирхол, үнэлэмжинд тулгуурласан нийгмийн зохион байгуулалтыг ардчилалд хамааруулж байв. Энэ онол нь аливаа ард түмний олон ургальч үзлийнх нь байдал, нийгмийн хүсэл, сонирхлын зөрчилт байдлыг нь аль болохоор бага илэрхийлдэг учраас удирдагчид ба удирдуулагчид гэсэн ойлголтын ялгаа бага байдаг. Мөн нийгмийн нийтлэг шинж байдлаас ондоо сонирхол, эрх ашгийг илэрхийлэх гэсэн оролдлогыг хүлээн зөвшөөрдөггүй. Иймд энэ онолыг баримталсан тохиолдолд дээрх шинжийг илэрхийлсэн хүн тухайн нийгэмд тэрс үзэлтэнд тооцогдож, амь насаа алдах нь түгээмэл зүйл болж болох юм. Ингэхлээр төрийн байгууллын энэ хэв маягыг улс төрийн философид тоталитар(totalitair) буюу "төрийн зохицуулалт бүхий ардчилал" хэмээн тодорхойлдог. Энэ нь нэг удирдагчийн эсвэл нэг намын зохион байгуулалт, удирдлаган дор ард түмэн урьдаас тодорхойлогдон, загварчлагдсан хөгжлийн хэв маягт хүчээр захирагдах явдал ажээ.

Английн нэрт философич Ж.Локкын философийн үзэл баримтлалаас үүдэлтэй АНУ-ын үндсэн хууль, түүний үйл ажиллагааны хүрээ нь "ардчиллын өрсөлдөөний(competetive) онол"-ыг бий болгон төлөвшүүлжээ. "Нийгэм бол ард түмэн дэх олон янзын эрх ашиг, хүсэл сонирхлоос бүрдэх

<sup>1</sup> (identitive, Оросын зарим судлаачид үүнийг прямая демократия гэж орчуулсан байдаг)

нь зүй ёсны зүйл бөгөөд үүнийг эрх зүйн тогтолцоогоор баталгаалжуулдаг” гэсэн үзэл энэ онолын үндсэн ойлголт нь болдог. Иймд улс төрийн хүсэл сонирхлыг илэрхийлэх үйл явц нь олон ургальч зарчимд тулгуурласан байдлаар зохион байгуулагддаг байна.

Нийгмийн гишүүд, бүлгүүдийн өөр хоорондоо сөргөлдөх, зөрчилдөх нь нэг нэгэндээ итгүүлэн үнэмшүүлэх гэж оролдох хамтын үйлдлийн наад захын хэлбэрээр илэрдэг. Нийгмийн хөгжлийн аль ч үед ард түмний олон янзын сонирхол, зөрчлийг төгс шийдвэрлэх арга гэж хэзээ ч байдаггүй. Үүнийг шийдвэрлэх хамгийн зохистой хэлбэр нь олонхийн шийдвэрийг дагах явдал байдаг. Гэвч зарим үед олонхиороо шийдвэрлэх арга зам нь хүртэл өөрөө “олонхийн дарангуйлалд” хүргэх магадлалтай байдаг байна. Ийм учраас, ардчиллын тухай уг онолыг хэрэгжүүлэхэд шаардагддаг хамгийн чухал зүйл цөөнхийн хамгаалалт бөгөөд орчин үед ч энэ асуудал улс төрийн философийн хүрээнд шийдвэрлэгдээгүй хэвээр байгаа.

Ардчиллын тухай үзэл баримтлал, онолын хөгжил нь орчин үед улам боловсронгуй болох шаардлага тавигдаж өмнө нь байгаагүй эсвэл төсөөлөгдөөгүй олон зүйлд анхаарал хандуулах шаардлага бий болгож байна. Энэ байдал нь сүүлийн үед дэлхийн улс орнууд ардчилсан хөгжлийн замд улам бүр олноороо шилжин орж байгаа үйл явцаас шууд хамааралтай юм. Нийгмийн хөгжлийн ардчилсан үйл явцын бодит илрэл, хэрэгжилт нь ардчиллын үзэл баримтлалууд дахь үндсэн ойлголтуудыг илүү нарийвчлан авч үзэх шаардлагыг бий болгож байна. Мөн нийгэмд илэрч буй зөрөг, сөрөг үр дагаварыг бий болгож байгаа үйл явцыг олон талаас нь судлан шинжлэх нь улам бүр чухал болсоор байна. Учир нь одоогоор дэлхий дээр оршиж байгаа тусгаар тогтнол бүхий 190 гаруй улсууд нь бараг бүгдээрээ нийгмийн хөгжлийн ардчилсан замыг сонгоод байгаа билээ.

Энэ нь нэг талаас хүн төрөлхтний нийгмийн хөгжил, техник технологи, боловсрол, шинжлэх ухаан, мэдээллийн нэг түвшинд тодорхойлогдох болсонтой. Нөгөө талаас, хүний оюун санааны хөгжлийн үйл явц эрчимжиж, энэ байдал нь хүний эрх чөлөө бол зайлшгүй байх ёстой зүйл гэсэн үзэл баримтлал орчин үеийн нийгмийг тодорхойлогч үндсэн ойлголт болоод байгаагаар шууд холбоотой юм.

Ардчилал бол орчин үеийн нийгмийн хөгжлийн түгээмэл шинж мөн хэмээх ойлголт нь улс төрийн философийн дийлэнх үзэл баримтлалуудад нэгэнтээ хүлээн зөвшөөрөгджээ. Эндээс ардчиллыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, даган мөрдөж байдаг үнэлэмж гэдэг утгаар оюун санааны үнэт

зүйлс хэмээн үзэж болно. Тэгвэл ардчилал хэмээх энэхүү оюун санааны үнэт зүйл нь нийгэмд дараах ойлголтуудаар дамжуулан өөрийн үнэ цэнийг илэрхийлдэг байна. Үүнд:

- ☞ Хүний эрх, эрх чөлөө
- ☞ Иргэдийн улс төрийн оролцоо
- ☞ Тэгш эрхийн зарчим
- ☞ Чөлөөт, ил тод сонгууль
- ☞ Нийтэд тайлагнах ёс
- ☞ Олон намын тогтолцоо
- ☞ Хуулинд захирагдах ёс
- ☞ Иргэний боловсрол; эдгээр болно

Эдгээрийг тус тусад дэлгэрүүлэн авч үзвэл:

*Хүний эрх, эрх чөлөө*

Хүний эрх бол хувь хүний нийгмийн харилцаанд оролцох боломж, түүний хэм хэмжээг илэрхийлсэн ойлголт юм. Ардчилал нь хүний эрхийг төрийн тусламжтайгаар баталгаажуулж, хүндэтгэн үзэх орчин нөхцөл байдлыг бий болгодог. Ардчилсан нийгэмд хүн бүр нийгмийн харилцаанд идэвхтэй оролцогч байх боломжтой байдаг. Энэхүү нөхцлийг ерөнхий утгаар эрх чөлөө гэдэг байна. Өөрөөр хэлбэл, эрх чөлөө гэдэг нэг талаас, нийт хүн төрөлхтөнд байгаа хүний эрх гэдэг ойлголтын ерөнхий нэр, нөгөө талаас, хүний эрхийг бүрэн утгаар бодитойгоор хэрэгжүүлэх нийгмийн боломж юм.

*Иргэдийн улс төрийн оролцоо*

Ардчилсан нийгэмд иргэд төрийн үйл ажиллагаанд оролцох нь тэдний зайлшгүй эдлэх ёстой эрх төдийгүй, иргэнийхээ хувьд хүлээж байгаа ёс суртахууны үүрэг юм. Иргэд улс төрийн үйл явцад оролцох явдал нь сонгуульд саналаа өгөх, нэрээ дэвшүүлэх, сонирхлын бүлэгтэй хамтарч ажиллах, жагсаал цуглаан хийх, татвар төлөх зэрэг олон янзаар илэрхийлэгддэг. Төр нь улс төрийн холбогдолтой шийдвэр гаргахад иргэд өөрсдийнхөө, улс орныхоо ирээдүйн хөгжлийн төлөө ухамсартайгаар, тодорхой зорилго чиглэлтэйгээр оролцох явдал бол ардчилсан нийгмийн байгууллын үндэс болдог.

*Тэгш эрхийн зарчим*

Ардчилсан нийгэм нь аливаа асуудалд бүх иргэд адил тэгш байр сууринаас хандах зарчмыг баримталдаг. Тэгш эрхийн зарчим гэдэг нь ямар ч иргэнийг нийгэм, улс төрийн ижил боломжтой байлгаж арьсны өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлахгүй байхыг хэлнэ.

*Чөлөөт, шударга сонгууль*

Ардчилсан нийгэмд олонхийн засаглалыг хэрэгжүүлдэг үндсэн хэрэгсэл бол чөлөөт сонгууль байдаг. Сонгууль нь аль зэрэг чөлөөтэй, ил тод, шударга, өргөн олон түмнийг хамарч явагдана, ардчилал төдийчинээ төлөвшсөн байгаагийн нэгэн илэрхийлэл болдог.

*Нийтэд тайлагнах ёс*

Төрийн албан хаагчид өөрсдөө ард түмний нэг хэсэг байдаг. Түүнчлэн ард түмнээсээ улс орныг удирдах эрхийг авдаг учраас эргээд тэдэнд өөрсдийнх нь төлөө хийсэн ажлаа тайлагнах нь ардчиллын үндсэн зарчмуудын нэг юм. Өөрөөр хэлбэл, тэд өөрсдийнхөө ашиг сонирхлын үүднээс бус ард түмний хүсэл, сонирхол, эрх ашигт нийцсэн хууль тогтоомж гаргаж, түүнийхээ дагуу үйл ажиллагаа явуулах ёстой. Энэ тэднийг өөрсдийн үйл ажиллагааны төлөө өндөр хариуцлага хүлээх зайлшгүй шаардлагатай болгодог байна.

*Олон намын тогтолцоо*

Нийгэмд нэг дор, нэг цаг хугацаанд олон нам зэрэг үйл ажиллагаа явуулж байх нь ардчиллын нэг гол шинж байдаг. Нийгэм дэх намуудын харилцан нөлөөлөл, хамтын үйл ажиллагааны цогцыг олон намын тогтолцоо гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, нийгэм дэх улс төрийн үйл явцад нэгээс дээш нам идэвхтэй оролцож, тодорхой үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг. Нийгэм дэх ардчилал нь үзэл баримтлалуудыг бүгдийг нь хүлээн зөвшөөрч, тэдгээрийг хөгжүүлэхийг чухалчилдаг учраас олон нам байна гэдэг нь олон ургальч үзлийг хөгжүүлэх уг сурвалж болж байдаг. Мөн ард түмэн тэрхүү олон янзын нам, нэр дэвшигч, улс төрийн бодлогын хувилбараас өөрт ашигтайг сонгох боломж бүрэлдүүлдэг байна.

*Хуулинд захирагдах ёс*

Ардчилсан нийгмийн нэг гол шинж нь хүн хийгээд нийгэмтэй холбоотой бүхий л зүйлийг хуулийн хүрээнд байлгана гэсэн зарчим байдаг. Энэхүү зарчим нь хүн бүр хуулийг сахин, түүнийг зөрчвөл хариуцлага хүлээнэ гэсэн утгатай. Ардчилсан нийгмийн орчинд бүхий л зүйл хуулийн тусламжтайгаар хэм хэмжээнд захирагдах бөгөөд энэ нь хөгжлийн үндсэн шинж байдаг. Тодруулбал, ардчиллын нөхцөлд хууль нь хүн бүхэнд ижил үйлчлэх бөгөөд хэн ч бай хуулиас гадуур байж, түүнийг даган мөрдөхгүй байх эрхгүй юм.

*Иргэний боловсрол*

Ардчилсан нийгмийн үндсэн зарчим бол иргэдийн боловсролын хэм хэмжээнд зохих хязгаарлалт хийхгүй байх явдал юм. Өөрөөр хэлбэл, боловсролтой иргэд ухаалаг, зөв сонголт хийж чадах бөгөөд энэ нь эргээд ардчилсан нийгмийг хөгжүүлэхэд тус дөхөм болдог байна.

АНУ-ын философич С.Хантингтон 1974 оноос хойшхи үеийг ардчиллын даяарчлалын буюу "хөгжлийн гуравдахь үйл явц" гэж нэрлэсэн байдаг. Учир нь 1974 оны 4 сард Португаль дахь цэргийн дарангуйлал бүхий тогтолцоо нуран унасан байдаг. Үүнээс үүдэлтэйгээр нийгмийн хөгжлийн ардчилсан хэв маягийг сонгон авах дэлхийн улсуудын нийтлэг байдал болсон гэж үздэг. Ийнхүү нийгмийн хөгжлийн түгээмэл шинж нь ардчилал болсноор энэхүү хөдөлгөөн эхлэх хүртэл дэлхий дээр ардчилсан улс гэж тооцож болох 40 орчим улс байсан. Гэтэл энэ тоо дээрх хөдөлгөөнөөс шалтгаалан 1970-аад оны сүүлч 1980-аад оны эхэн үед улс орнууд авторитар (дийлэнх нь цэргийн) дэглэмээс ардчилсан нийгмийн хэв маягт шилжиж эхэлснээр аажмаар өсөж эхэлсэн байна. Ардчиллын энэхүү "гуравдахь хөгжлийн үйл явц"-ыг ингэж эрчимтэй явагдахад нөлөөлсөн нийгмийн нөхцөл байдлуудыг дурьдвал:

Ардчилалд шилжих сонирхол: Энэ бол ардчилсан бус нийгмийн хөгжлийн хэв маягаас ардчилсан хэв маягт шилжих түүхэн үйл явц, түүний тодорхой нэг үе шат, мөчлөг юм. Ийм түүхэн үйл явцад нийгмийн хөгжлийн эерэг шинжтэй үйл ажиллагаанууд нь сөрөг шинжтэй үйл ажиллагаануудаас олон байдаг. Гэхдээ нийгмийг ардчилах үйл явцад хамрагдсан улс орон болгоныг "ардчилсан улс" гэсэн ангилалд шууд оруулж болдоггүй. Нийгмийн ардчилсан үйл явц нь хөгжлийн тодорхой үе шатуудтай байдаг нь үүнтэй холбоотой. Нийгэмд өрнөсөн ардчилсан үйл явц нь өөрөө тухайн нийгмийн хөгжилд тодорхой үе шатуудыг даван туулах шаардлагыг заавал бий болгодог. Үүнийг урьд нь авторитар дэглэмтэй байгаад түүнээсээ ардчилсан дэглэмд шилжсэн улсуудын жишээнээс харж болно.

Ардчиллын хөгжлийн түгээмэл үйл явц: Ардчилал дахь хөгжлийн үйл явц нь "гуравдахь хөгжлийн үйл явц" эхэлсэн үеэс мэдэгдэхүйц хурдассан юм. 1974 онд дэлхий дээр 39 улсыг ардчилсан хэмээн тооцож байв. Гэтэл тэдгээрээс 28 улс нь л нэг саяас дээш хүн амтай байсан ажээ. Түүнчлэн дэлхий дээрх нэг саяас дээш хүн амтай улсуудын 23 хувь нь, мөн дэлхийн нийт улсуудын 27 хувь нь ардчиллыг нийгмийн хөгжлийн төдий л сайн хэв маяг гэж үзэхгүй байлаа. Энэ үед хийгдсэн зарим нэг судалгаанаас үзэхэд улс орнуудын хүн ам, газар нутгийн хэмжээ болон оршин тогтнож байсан

хөгжлийн хэв маяг хоёрын хооронд сонирхолтой харилцан хамаарал ажиглагдаж байв. Тухайлбал, нэг саяас бага хүн амтай жижиг улс нь томоохон улсыг бодвол ардчилсан, ялангуяа либераль ардчилсан улс болох боломж ихтэй байсан байна. Энэ байдал нь тухайн үед нийгмийн масс нь уламжлалд ихээхэн автагдсан байдаг тухай Германы философи Ф.Ницшегийн үзэл баримтлалаар тайлбарлагдаж байна.

Ардчиллын бэхжилт: Аливаа улс оронд ардчилал бэхжих гэдэг нь ард түмний бүхий л хүрээнд хүлээн зөвшөөрөгдөнө гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, элитийн, жирийн ард түмний түвшинд ч тэр нийгмийн хөгжлийн хамгийн зохистой хувилбар бол ардчилсан хэв маяг юм хэмээн итгэлтэй байхад оршино. Энэхүү бэхжилт гүнзгийрэхийн хирээр ард түмэн өөрсдийн үзэл бодолдоо бат итгэж, төвийг сахисан, аливаа үйл байдлыг хүлээсэн улс төрийн оролцооноос аль болохоор татгалзаж эхэлдэг. Энэхүү байдалтай холбоотойгоор төрөлжсөн байгууллагуудад үйл ажиллагааных нь загвараар бус, харин "зарчмын" хандлагаар хандах нь аажмаар нэмэгддэг. Энэ байдал нь улс төрийн эсрэг тэсрэг хүчнүүдийн хоорондын хамтын ажиллагааг идэвхижүүлж, бие биедээ итгэх итгэлийг нэмэгдүүлдэг байна.

Мөн нийгэм дэх ардчиллын бэхжилт нь улс төрийн үйл ажиллагаан дахь бүтцийн болон үйл байдлын өөрчлөлтөнд нөлөө үзүүлдэг. Энэ нь төрийн удирдлагыг сайжруулж, түүний санхүүгийн чадварыг бэхжүүлж, эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, авилгал ба дангаар ноёрхолыг хязгаарласан хуулийн тогтолцоог бүрэлдүүлэх зэрэгт шууд нөлөөлдөг. Нөгөө талаар, улс төрийн тогтолцоон дахь замбараагүйдлыг зогсоох, хууль тогтоох болон орон нутгийн өөрийн удирдлагын биеэ даасан байдлыг бэхжүүлэх, иргэний нийгмийг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Орчин үед нийгмийн ардчилах үйл явц дараах гурван онцлог нөхцөл байдлыг бий болгож байна. Үүнд:

- Орчин үед цэргийн хүчээр засгийн эрхийг булаан авах боломж бараг алга болоод байна. Өөрөөр хэлбэл, цэргийн хүчээр төрийн эргэлт хийх явдлыг ард түмэн дэмжихээ больжээ. Үүний гол шалтгаан нь ийм төрлийн төрийн байгууламж нь ард түмэнд төдийлөн үр ашигтай бус, гол төлөв харгис ширүүн үйл ажиллагаа явуулж байсан нь цэргийнхний нэр хүндийг унагасан байна. Тодруулбал, ард түмний дунд цэргийн хүрээнийхэн нийгэм-эдийн засгийн төвөгтэй асуудлуудыг бие даан шийдвэрлэж чадна гэх итгэл багассан гэсэн үг. Ингэснээр, нийгмийн хөгжилд оруулах цэргийнхний үүргийг тодорхой

## МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

хэмжээгээр хязгаарлах, тэднийг шийдвэр гаргагч энгийн иргэнд захируулах явдлыг чухалчлах болжээ. Жишээ нь, Батлан хамгаалах яамны сайд нь энгийн хүн байх гэх мэт. Энэ байдал нь цэргийнхэн улс төрийн, харин улс төрчид цэргийнхэнтэй холбоотой асуудалд хөндлөнгөөс оролцох явдлыг багасгахад хүргэж байна.

➤ Ардчилсан хөгжлийн чиг шугамаар хөгжиж байгаа улс орнуудад зарим тохиолдолд ардчиллын бэхжих (консолидаци) үйл явц удаашралтай явагдаж байгаа байдал элбэг байна. Мөн цөөн улсуудын хувьд зарим талаараа хэсэгчилсэн бүр улам муудах төлөв ажиглагдаж байна. Гэвч тухайн улсуудын иргэд буцаад хуучин нийгмийн хэв маяг руугаа буцах хүсэлтэй байгаа тохиолдол огт ажиглагдаагүй юм.

➤ Орчин үед нийгмийн хөгжлийн үйл явцыг илэрхийлэгч гол үзэл баримтлал болоод байгаа ардчилалтай эн зэрэгцэх эсвэл түүний эсрэг шинжтэй өөр үзэл суртал хараахан байхгүй байна.

Төрийн албан хаагчид, засгийн эрх баригчид мөн бусад улс төрийн оролцогчид өөрсдийн үйлдлээс сайтар хянаж, цэгнэж байх шаардлага байнга гарч байдаг. Өөрөөр хэлбэл, тэд иргэний эрх чөлөө, улс төрийн эрх болон үндсэн хуулинд заасан төрийн засаглалын хязгаарлалтанд хүндэтгэлгүй хандахын хирээр ардчиллын үйл явцыг доголдолд оруулдаг. Ийм байдал нь ардчиллын бэхжилтийг удаашруулдаг байна. Энэ зөвхөн сонгуулийн ардчиллыг л бий болгодог бөгөөд энэ бол ардчиллын тийм ч хангалттай байдал биш. Сонгуулийн ардчилал нь зарим үед өнгөц, хяналтгүй, байх нь элбэг байдаг. Ийм нөхцөлд хүний, бүлгийн эрхэнд халдах нь улам ихсэх ба ингэхийн хирээр ардчиллыг ард түмэнд хүлээн зөвшөөрүүлэх, түүнийг хадгалахад төвөгтэй болж, элдэв сөрөг хүчин зүйл бий болдог. Ийм тохиолдолд эсрэг хүчнийхэн оршин байгаа нийгмийн тогтолцоог үндсээр нь өөрчлөхөд хялбар болно. Ийм учраас ардчиллыг бэхжүүлэхийн тулд сонгуулийн ардчиллыг хөгжүүлэн, гүнзгийрүүлж либераль ардчилал болгон төлөвшүүлэх ёстой.

### Ашигласан ном зохиол

1. Robert A. Dahl. Polyarchy: Participation and Opposition. New Heaven, 1971.
2. Arend Lijphart. Democracies. Patterns of Majoritarian and Consensus Government in Twenty-One Countries. New Heaven-London, 1984, p. 2.
3. R.A.Dahl. Polyarchy. p. 3. 1973.